



МОНГОЛ УЛС  
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 03 сарын 29 өдөр

Дугаар А/162

Номгон

Мэргэжлийн Боловсрол сургалтын Үндэсний  
зөвлөлийн орон нутгийн салбар зөвлөл  
байгуулах тухай

Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Боловсролын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.2, Мэргэжлийн боловсрол сургалтын Үндэсний зөвлөлийн 2010 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн хуралдааны 08 дугаар тогтоолоор батлагдсан “Мэргэжлийн боловсрол сургалтын Үндэсний зөвлөлийн Орон нутгийн салбар зөвлөлийн удирдлагыг томилох, гишүүнийг сонгох, баталгаажуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Мэргэжлийн боловсрол сургалтын Үндэсний зөвлөлийн Орон нутгийн салбар зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Салбар зөвлөлийн дарга: Аймгийн Засаг даргын орлогч

Дэд дарга: Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн Хөдөлмөр, нийгмийн хамгаалал, халамжийн асуудал хариуцсан мэргэжилтэн

Гишүүд: Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын Хөдөлмөр эрхлэлтийн хэлтсийн дарга

Боловсрол, шинжлэх ухааны газрын дарга

Ажил олгогч эздийн холбооны дарга

Баянхонгор аймаг дахь Худалдаа аж үйлдвэрийн танхимын дарга

Ажил олгогчдын төлөөлөл

Багш, ажиллагсдын төлөөлөл

Нарийн бичгийн дарга: Мэргэжлийн боловсрол сургалтын байгууллагын захирал

2.Мэргэжлийн боловсрол сургалтын Үндэсний зөвлөлийн орон нутгийн салбар зөвлөл нь Мэргэжлийн боловсрол сургалтын Үндэсний зөвлөлийн 2010 оны 08 дугаар сарын 05-ны өдрийн хуралдааны 07 дугаар тогтоолын хавсралтаар

842310397


2.

батлагдсан “Мэргэжлийн боловсрол сургалтын Үндэсний зөвлөлийн Орон нутгийн салбар зөвлөлийн дүрэм”-ийг баримтлан ажиллахыг үүрэг болгосугай.

3.Мэргэжлийн боловсрол сургалтын Орон нутгийн салбар зөвлөлийн ажлыг дүрэмд заасан чиг үүрэг, үйл ажиллагааны дагуу хэрэгжүүлж, тайланг аймгийн Засаг даргын зөвлөлд танилцуулан холбогдох арга хэмжээг авч ажиллахыг орон нутгийн салбар зөвлөлийн даргад үүрэг болгосугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтсийн даргад даалгасугай.

5.Энэ захирамж гарсантай холбогдуулан Аймгийн Засаг даргын 2021 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн А/141 дүгээр захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА  Д.МӨНХСАЙХАН